

## АМЕРИКИЙН ЖИЖИГ БИЗНЕС: ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Т.Бат-Амгалан\**

Америкчууд өөрсдийгөө амьдрах боломжоор бүрэн дүүрэн хангагдсан оронд амьдардаг хүмүүс гэж үздэг. Америк оронд санаачлагатай, шийдэмгий, ажилсаг хэн боловч өөрийн гэсэн бизнесээ эрхэлж, өсөн өндийх бүрэн боломжтой гэдэгт итгэдэг. Амьдрал дээр хүмүүсийн дээрхи итгэл үнэмшил нь хувиараа хөдөлмөр эрхлэхээс эхлэн, дэлхийн хэмжээний конгломират хүртэлх олон хэлбэрийн бизнес эрхлэх боломж нөхцлийг төрөөс бүрэн дүүрэн хангаж өгснөөр баталгааждаг.

Америкийн түүхийн аль ч үед улс орны эдийн засагт жижиг бизнес шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж ирсэн байна. АНУ-ын жижиг бизнесийн байгууллагын мэдээгээр Америкийн ажиллах хүчний 52% нь жижиг бизнесийн салбарт ажиллаж байна.

Өнөөгийн байдлаар 20 гаруй сая Америкчууд 20-иос доош хүнтэй компанид ажиллаж байна. Түүнээс гадна 11 сая гаруй нь нэг хүний эзэмшилтэй пүүс, 2 сая гаруй нь нөхөрлөл байдаг аж. Энэ бүхнээс үзэхэд жижиг бизнес өнөөдөр ч гэсэн АНУ-ын эдийн засгийн өсөлт хөгжлийн үндэс суурь болсон хэвээр байгааг харуулж байна.

Өсөлт хөгжлийн хүчирхэг хөдөлгүүр болсон жижиг бизнесийн түүхэн замнал, төрийн зохицуулалт, туршлага сургамж нь шилжилтийн жижиг эдийн засагтай манай орны хувьд анхаарч үзэх, санаа авахад хэрэг болох болов уу хэмээн санана.

Америкчуудын жижиг бизнест итгэх итгэл үнэмшил XVIII зууны сүүлчээс төлөвшсөн гэж үздэг байна. Төмөр зам, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн хөгжил боловсронгуй болохын хэрээр хөрөнгө түлхүү шаардлагатай байсан үйлдвэрлэлийн салбар болох метал боловсруулалт, машин тоног төхөөрөмжийн эд анги болон химийн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх үр ашигтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд оршиж байв. Энэ чиглэлээр төрөөс хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, санхүүгийн эх үүсвэр бий болгох чиглэлээр чухал чухал арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн байдаг.

Тухайлбал, 1887 онд АНУ-ын конгресс муж улс хоорондын худалдааны хууль нэртэй хууль баталсан нь төмөр замын үйл ажиллагааг хуульчлах, жижиг бизнес эрхлэгчдийг өрсөлдөөнөөс хамгаалах зорилготой байсан юм. Дээрх хууль гарснаар жижиг бизнес эрхлэгчдэд зохих ач холбогдол өгсөн хэдий ч орон нутгийн чанартай зах зээл үндэсний хэмжээний зах зээл болон өргөжиж тэлж байсан

\* Т.Бат-Амгалан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

явдал байнга өсөн нэмэгдэж ирсэн үйлдвэрлэлийн механикжилт улам бүр өргөжин тархах болсон үйлдвэрлэлийн газруудын хувь нийлүүлсэн хэлбэр “Трестүүд” буюу үйлдвэрлэл, худалдааны монополын хөгжил жижиг бизнес эрхлэгчдэд том цохилт болж эхэлсэн байна. Тийм учраас түүхэнд “Трестийн эсрэг хуулиуд” гэж алдаршсан хуулиуд гаргахад хүрсэн. Трестийг эсэргүүцсэн жижиг бизнес эрхлэгчид болон олон нийтийн дургүйцэл 1870-1880 онд дээд цэгтээ хүрч, түүнийг таслан зогсоохын тулд 1890 онд Трестийн эсрэг Шерманы хууль гарав. Энэ хууль гайхалтай товчхон болсон хэдий ч асуудлын голыг шууд хөндсөнд оршино. Хуулийн гол утга санааг үндсэн хоёрхон зүйлд багтаасан.

1-р зүйл: Үйлдвэрлэл худалдааг хязгаарлах зорилго бүхий хэд хэдэн мужийн хооронд буюу гадаад улс орнуудтай байгуулсан аливаа хэлэлцээр, трестийн буюу өөр хэлбэрээр байгуулсан нэгдэл эсвэл нууц хуйвалдаан зэрэг нь хууль бусд тооцогдоно.

2-р зүйл: Хэд хэдэн мужийн хооронд эсвэл гадаад улс орнуудтай үйлдвэрлэл худалдааны нэг хэсгийг монополь болгохын тулд хэн нэгэн этгээдтэй нэгдэх, эсвэл хуйвалдах, монополь болгохыг завдсан буюу тийм үйлдэл хийсэн аливаа этгээдийг гэмт хэрэг үйлдсэн буруутанд тооцно. Хуулийн дээрхи заалт жижиг бизнес эрхлэгчдэд төдий л үр ашгаа өгөөгүй тул хуулинд зайлшгүй нэмэлт тодруулга хийх шаардлагатай болсон. Үүнийг 1914 оны Клейтоны хуулиар тодруулсан. Улмаар 1936 онд Р.Патманы хууль, 1937 онд Миллер Тайдын хуулиуд гарсан нь томоохон сүлжээ дэлгүүрүүдийг хянах зорилготой байв. Трестийн эсрэг хуулиуд нь монополийн хөгжилд саад хийж, эсвэл нэгэнт үүсэн бий болсон монополийн үйл ажиллагааг төрөөс зохицуулалт хийж, жижиг бизнест дэмжлэг үзүүлэхэд чиглэж ирсэн байна. Трестийн эсрэг дээрхи хуулиуд жижиг бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалж чадахгүй байна. Эдийн засаг дахь төрийн оролцоо, зохицуулалтыг улам боловсронгуй болгох ёстой гэсэн шахалт шаардлага жижиг бизнес эрхлэгчдийн зүгээс байнга гарч байв. Төрөөс жижиг бизнес эрхлэгчдийн дээрхи шаардлагыг хүлээн авч том бизнесийн өрсөлдөөн, монополийг хязгаарлах талаар төрийн хяналтыг хүчтэй болгосон явдал Америкийн жижиг бизнес эрхлэгчдэд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм. Гэсэн хэдий ч жижиг бизнес эрхлэгчид төрийн зохицуулалтын гадна байсаар ирэв.

1953 онд хууль санаачлагчид жижиг бизнес эрхлэгчдэд зориулж жижиг бизнесийг удирдах байгууллага байгуулах асуудлыг боловсруулж, хууль гаргасан явдал жижиг бизнесийн хөгжилд хүчтэй дэмжлэг болсон боловч энэ байгууллага нь холбооны засгийн газрын агентлаг ба жижиг бизнес эрхлэгчдийг төлөвшүүлэх, эрсдэлгүй хөрөнгө

оруулалт хийх, засгийн газрын агентлагуудтай газрын гэрээ хийх, хувьцаагаа өсгөх, төрийн зүгээс жижиг бизнес эрхлэгчдэд зүйл бүрээр туслах зорилготой юм. Тиймээс засгийн газрын оролцоо жижиг бизнесийнхний хувьд туйлын чухал субъект болж чадсан юм.

Өнөөдөр Америк орныг сонирхсон хэний ч хувьд АНУ бол том том үйлдвэр корпорациудаас бүрдсэн орон гэж ойлгогддог ч үнэн хэрэгтээ компаниудын 99 хувь нь жижигт тооцогддог ба 500-аас доош ажилтантай байдаг байна. 1990-1995 оны хооронд эдийн засаг дахь нийт шинэ ажлын байрны 3/4 хувийг энэ салбар эзэлж байгаа нь өмнөх арван жилүүдээс ч харьцангуй илүү үзүүлэлт аж. Жижиг бизнес нь дотроо эдийн засаг дахь зарим бүлгүүдийг төлөөлдөг бөгөөд үүний жишээ нь эмэгтэйчүүд далайцтайгаар жижиг бизнест их хамрагддаг байна. Тухайлбал, нийт бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн 89% нь жижиг бизнесийн салбарт хамрагддаг байна. Мөн жижиг бизнесийнхэн өндөр настангуудыг ажилд авах болон хүмүүсийг богиносгосон цагаар ажиллуулах чиг хандлагатай байна. Эдийн засгийн нөхцөлд ямар нэг өөрчлөлт гарахад жижиг бизнесийнхэн нөхцөл байдалд маш хурдан дасан зохицож, хариу өгөх бодит чадвартай байдаг. Тэд үйлчүүлэгч нараа дотно мэдэхээс гадна ялангуяа тухайн орчныхоо хэрэгцээг хангахад илүү тохирсон байдаг аж. Ер нь бизнест шинэ санаа хамгийн чухал. Үүний нэг жишээ гэвэл гараждаа аз туршин компьютерийн сэлбэг нийлүүлэн суугаад юм зохиочихдог байсан залуу өнөөдөр АНУ-ын Калифорни мужийн Silicon Valley компанийг үүсгэн байгуулж, компаниа маш богино хугацаанд корпорацийн хэмжээнд хүргэж чаджээ. Жижиг компаниас үйл ажиллагаагаа эхэлж үндэсний болон дэлхийн зах зээл дээр томоохон өрсөлдөгч болсон компаниуд гэвэл компьютерийн програмын Microsoft, Дэлхийн шуудангийн үйлчилгээний FED EX, спорт барааны Nike, компьютер сүлжээний America online зэрэг олон алдартай пүүс компаниудыг нэрлэж болох юм.

Америкт өнөөдөр жижиг бизнес эрхлэхээр зориг шулуудсан хэнд ч гэсэн үйл ажиллагаа явуулах хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, үл хөдлөх хөрөнгө болон бизнесийн зориулалтаар машин тоног төхөөрөмж худалдан авахад нь зориулж төрөөс зүйл бүрээр хөхиүлэн дэмжсээр байна. Төрийн зүгээс энэ ажлыг жижиг бизнесийг удирдах байгууллага эрхэлдэг. Энэ байгууллага жижиг бизнес эрхлэгчдэд зориулж жил бүр 10 тэрбум ам.долларын батлан даалт гаргаж урт хугацаатай зээл олгодог. Тэд төрийн энэ дэмжлэгийг өөрийн бизнест шаардлагатай эргэлтийн хөрөнгө бүрдүүлэх, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, машин тоног төхөөрөмж худалдан авч, жижиг бизнесээ хөл дээр нь босгох, ажлын шинэ байр бий болгоход үр бүтээлтэй ажиллаж чаддаг.

Америкт жижиг бизнесийг дэмжин төрийн зохицуулалттай хөгжүүлж буй өнөөгийн практик дэлхийн улс орнуудад ч түгэн тархаж, өсөлт хөгжлийнх нь уг сурвалж болж байна. Энд бид Хятад улс жижиг бизнес эрхлэгчдийг хэрхэн туслан дэмжиж, тариачдыг ядуурлаас аварсан тухай товч өгүүлье. 1970-аад онд Хятадын нэгэн туйлын ядуу хамтралын тариачид өлсгөлөнд нэрвэгдсэн байдалтай байснаа аз туршихаар шийдэн, нууцаар газар нутгаа хуваан авч ашиглаж эхэлсэн байдаг. Ингэж тариачид өөрийн гэсэн тариалангийн газартай болсноор өөрсдийн хүнсний хэрэгцээг бүрэн хангаад зогсохгүй үлдсэн тариагаа борлуулдаг болсон гэдэг. Нэг жилийн дотор энэ хамтрал Хятад улсыг гайхшруулж коммунист үзэл сурталд өртсөн хэдий ч Хятадын засгийн газар тэднийг коммунист үзэл суртлын эсрэг зүйл хийсэн гэж зэмлэхгүйгээр тариачдад хэсэг газрыг нь албан ёсоор өгөхөөр болсон түүхтэй. Тиймээс Хятадын энэ “капиталист” үзэл санаа 20-иод жилийн дотор олон сая хүнийг ядуурлаас аварч чадсан төдийгүй ядуурлын эсрэг хамгийн алдартай хөтөлбөр болж, дэлхийн түүхэнд тэмдэглэгдсэн билээ. Өөрөөр хэлбэл жижиг бизнес нь өлсгөлөн, ядууралд нэрвэгдсэн улс орнуудын ядуурлыг бууруулахаас гадна, дунд ангийг үүсгэн бүрдүүлж улмаар нийгмийн тогтвортой байдлыг бий болгодог байна.

Жижиг бизнесийг хөгжүүлэхэд засгийн газрын бодлоготой холбоотой хэдэн чухал зүйлийг энд авч үзье.

Аль ч орны төрөөс жижиг бизнесийг дэмжих чиглэлээр төсөл хэрэгжүүлэх гэж байгаа бол хувийн хэвшлийнхний бизнесийн дагуул түүний салшгүй нэг хэсэг эрсдэлийн тухай асуудлыг маш нухацтай авч үзэх шаардлагатай байдаг аж. Эрсдэлийн тодорхой хувийг төр хөрөнгийн батлан даалт гаргах замаар хуваалцах үүрэг хүлээсэн хууль эрх зүйн зохицуулалт маш чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Энэ тохиолдолд хүмүүс жижиг бизнест татагддаг байна. Тэгэхээр жижиг бизнесийн хөгжлийг дэмжих анхны гараа бол бизнес эрхлэгч нарт үйл ажиллагаагаа эхлэхэд нь хөрөнгийн эх үүсвэр олж өгөхөд туслах явдал юм. АНУ-ын хувьд засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох жижиг бизнесийг удирдах байгууллага буюу SBA чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг дээр өгүүлсэн билээ. Энэ байгууллага нь бизнесээ эхэлж байгаа хүмүүст хэдий хэр хөрөнгийн эх үүсвэр хэрэгтэй байгаа тэр хэмжээгээр нь олж өгөхийг эрмэлздэг. Гэсэн хэдий ч мөнгө зээлдэггүй харин тэдэнд баталгаа гаргаж өгдөг. Харин ийм төрлийн засгийн газрын болон SBA-н батлан даалтанд байгаа аж ахуйн нэгжид банкууд ямар ч асуудалгүй мөнгө зээлдэг ажээ. Тийм ч учраас АНУ-ын эдийн засгийн 99% нь жижиг бизнесийн бүлэгт хамрагддаг. Түүнд хамрагдахыг ч тэд их хүсдэг. Тэгэхээр ямар ч засгийн газар жижиг бизнесийг дэмжих гэж байгаа бол засгийн

газраас батлан даасан зээлийн сан байгуулах шаардлагатай бөгөөд эргэлтийн хөрөнгийг хялбаршуулснаар амьд жижиг бизнесийн салбарын баазтай болдог байна.

**Бизнес хийх сонирхолтой хүмүүсийг сургах нь:** АНУ-ын засгийн газраас ба SBA-с явуулж буй бас нэгэн чухал бодлого нь бизнес эрхлэгч нарыг сургах асуудал юм. Үүнд:

- Бизнесийн инкубатор байгуулах. Бизнесийн инкубатор нь бизнесийг хаанаас яаж эхлүүлэх, ямар байдлаас эхлүүлэх талаар зааварчилгаа өгнө. Эдгээр инкубаторууд нь ихэвчлэн их дээд сургуулийн професорууд, мэргэжилтэн нар хамтарч ажилладаг бөгөөд худалдаа, маркетингээс авхуулаад хууль татвар хүртэлх хэмжээний мэдлэгийг олгодог байна. АНУ-ын Засгийн газар их, дээд сургуулиудыг бизнес инкубатортай болоход нь онцгой анхаарч ихээхэн дэмжлэг туслалцаа үзүүлдэг.

- Интернет сургалт. АНУ-ын хувьд SBA нь өөрийн веб хуудсандаа жижиг бизнес эрхлэгч нарт зориулсан хичээл болон бизнесийн олон тооны шинэ санаа санал болгосон байдаг. Сонирхосон хэн боловч [www.Sba.gov/training/coursetake.html](http://www.Sba.gov/training/coursetake.html) гэсэн хаягаар орж үзэх боломжтой.

Үүнээс гадна зөвхөн шинээр жижиг бизнес эрхлэгч нарыг л дэмжих бус оршин тогтнож буй жижиг бизнес эрхлэгч нарыг урамшуулах, тэднийг жил болгон үйл ажиллагааных нь хувьд шалгаруулж, олон түмэнд таниулах асуудлыг засгийн газраас санхүүжүүлэх явдал маш чухал байдаг байна.

**Оюуны өмчийг хамгаалах нь:** Жижиг бизнесийг дэмжсэн ямар ч засгийн газар бизнес эрхлэгч нарынхаа шинэ санааг хамгаалсан хууль тогтоомж гаргах хэрэгтэй байдаг. Шинэ санаа бол жижиг бизнесийн хөгжлийн хамгийн гол хөдөлгүүр нь байдаг тул хэрэв хуулиар хамгаалахгүй бол жижиг бизнесийнхэн эрсдлээс гарах шинэ санаа олох ямар ч боломжгүй байх нь тодорхой. Жижиг бизнесийг хэрэгжүүлэхийг зорьж буй аль ч улсын засгийн газар бага эрсдэл үүрэн илүү ихийг олох хөтөлбөр боловсруулах зайлшгүй шаардлагатайгаас гадна эрх зүйн орчин бүрдүүлж, бие даасан агентлаг байгуулах нь хамгийн чухал хүчин зүйл болохыг энд зориуд цохон тэмдэглэх нь зүйд нийцэх биз ээ.

**Ашигласан эх сурвалж**

1. Info USA Year book 2007, US Department of State
2. Small Business Administration (SBA) <http://www.sba.gov/>
3. An Outline of the American Economy
4. The History of the American Economy – Walton Rockoff
5. Ewing Marion Kauffman Foundation. *Understanding Entrepreneurship: A Research and Policy Report*. Kansas City: Ewing Marion Kauffman Foundation, 2005.  
[http://research.kauffman.org/cwp/jsp/redirect.jsp?&resourceId=Research/Resource/Report\\_070.htm](http://research.kauffman.org/cwp/jsp/redirect.jsp?&resourceId=Research/Resource/Report_070.htm)
6. Gardiner, Rebecca. “Business, African Style.” *Profit*, vol. 24, no. 4 (September 2005): p. 17. [http://www.profitguide.com/exporting/article.jsp?content=20050927\\_170636\\_5564](http://www.profitguide.com/exporting/article.jsp?content=20050927_170636_5564)
7. Johnson, Pitch. “Entrepreneurship and Democracy.” *Hoover Digest*, no. 1 (Winter 2005): pp. 152-156.  
<http://www.hooverdigest.org/051/johnson.html>
8. Karlgaard, Rich. “It’s the Entrepreneurs, Stupid!” *Forbes*, vol. 176, no. 1 (4 July 2005): p. 39.  
[http://www.forbes.com/global/2005/0704/075\\_print.html](http://www.forbes.com/global/2005/0704/075_print.html)
9. Entrepreneur.com: Solutions for Growing Businesses  
<http://www.entrepreneur.com/>  
<http://www.entrepreneur.com/howto/0,5967,,00.html>
10. F.M. Scherer. *Industrial Market Structure and Economic Performance*. 2<sup>nd</sup> edition. Chicago: Paul McNally and Company, 1980